



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Спортын тэмцээн зохион байгуулах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны спортын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны спортын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээний удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээний зардлыг батлагдсан төсвийн дагуу тооцон олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

4. 2023 оны 04 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд ажлын байрны дэг журамд хяналт тавьж, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг ханган ажиллахыг цех, хэлтсийн дарга, ИТА нарт, Спортын уралдаан тэмцээнийг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулахыг Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч (Ш.Отгонбаярмаа)-д, тэмцээн зохион байгуулагдах өдрүүдийн сахилга, дэг журамд хяналт тавьж гарсан зөрчлийг шуурхай шийдвэрлүүлж ажиллахыг Хуулийн мэргэжилтэн (Г.Саруул)-д тус тус үүрэг болгосугай.

5. Тэмцээнд оролцож байгаа баг, тамирчдад тоглолтын үеийн аюулгүй байдал, галын аюулгүй байдлын зааварчилгааг өгөхийг Хяналтын хэлтэс (П.Зоригоо)-д даалгасугай.

6. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Э.Мөнхжаргал), Захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Б.Ган-Очир), Хяналтын хэлтсийн дарга (П.Зоригоо) нарт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МОНХХӨӨ

• 132301341